

Журам батлах тухай

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 9.13 дахь хэсэг, 10.1.1 дэх заалт, Засгийн газрын 2012 оны “Зохицуулах зөвлөлийн дүрэм батлах тухай” 46 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм”-ийн 3.1.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний үнэ тарифийн саналыг хянан шалгах дотоод журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифийн алба /Ж.Гэрэлчулуун/-д даалгасугай.

ДАРГА

Ч.ЭРДЭНЭЧИМЭГ

ГИШҮҮД

Б.ЖИГЖИД

Ч.БАТТОГТОХ

С.ЧУЛУУНХУЯГ

Р.НЯМЖАВ

Зохицуулах зөвлөлийн 2012 оны дүгээр сарын
.... –ний өдрийн дугаар тогтоолын хавсралт

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФЫН САНАЛЫГ ХЯНАН ШАЛГАХ ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн дагуу тухайн нутаг дэвсгэрт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний үнэ тарифыг тогтоолгохоор ирүүлсэн саналыг хянан шалгах, энэхүү үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, оролцогч талуудын эрх ашгийг тэнцвэртэй хангасан үнэ тарифыг Зөвлөлөөр батлуулах үүнд олон нийтийн оролцоо, мэргэжлийн байгууллагуудын санал, дүгнэлтийг тусгахад оршино.

1.2. Үнэ тарифын саналыг хянан шалгах дотоод журам нь “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”, “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль” Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-өөс баталсан тогтоол, шийдвэрт нийцсэн бөгөөд Зөвлөлийн холбогдох алба үнэ тарифын талаарх саналыг хүлээн авч, хянан шалгах дотоод үйл ажиллагааг зохицуулна.

1.3. Үнэ тарифын саналыг хянах, шалгах үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид “ТЗЭ” гэж товчлох/, Зөвлөл болон эрх бүхий байгууллага, албан тушаалтан, олон нийтийн оролцоо нь тэгш зарчмын үндсэн дээр хэрэгжинэ.

1.4. Журам нь үнэ тарифын саналаа ирүүлэх, үнэ тарифын саналыг хүлээн авах, хэрэглэгчдэд мэдээлэх, хэрэглэгчдийг санал өгөх боломжоор хангах, нууц мэдээлэл, хяналт, шалгалт, зөвшилцөл, шийдвэр гаргах гэсэн хэсгээс бүрдэнэ.

Хоёр. Тарифын саналаа ирүүлэх

2.1. ТЗЭ нь “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль” болон Зөвлөлөөс гаргасан дүрэм журамд нийцүүлэн

хэрэглээний цэвэр ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, зөөвөрлөн түгээх ба бохир ус татан зайлуулах, цэвэршүүлэх үйлчилгээний үнэ тарифыг өөрчлүүлэх саналаа Зохицуулах зөвлөлд нь ирүүлнэ.

2.2. Хүсэлтийг Зөвлөл хүлээж аваад, онцгой нөхцөлд хугацааг хойшлуулж болно.

2.3. ТЗЭ-ийн ирүүлсэн үнэ тариф өөрчлөх санал, хүсэлтийг Зөвлөл “Өрсөлдөөний тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай зөвшилцөнө.

2.4. ТЗЭ-ийн Зөвлөлд ирүүлэх үнэ тариф өөрчлөх саналд дараах агуулгыг заавал багтаасан байна. Үүнд:

2.4.1. Байгууллагын талаарх товч мэдээлэл, үнэ тариф өөрчлөх болсон үндсэн шалтгаан, өөрчилснөөр компанийн санхүүгийн байдал, хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөлөл;

2.4.2. Мөрдөгдөж байгаа болон шинээр мөрдөгдөхөөр санал болгож буй үнэ тарифын бүтэц, хэмжээг харуулсан хүснэгт;

2.4.3. Үнэ тарифт өөрчлөлт оруулах үндэслэл, холбогдох мэдээ, баримтыг Зөвлөлөөс баталсан аргачлал, зохих маягтын дагуу;

2.4.4. Хэрэглэгчийн тоо, хамрагдах хүрээ, ангилал зэргийг харуулсан хүснэгт;

2.4.5. Удирдлагаас баримталж буй бодлого, хөтөлбөрийн хураангуй, стратегийн болон богино хугацааны төлөвлөгөө, бизнесийн хөгжлийн болон зохион байгуулалтын асуудлууд, хөрөнгө оруулах хэрэгцээ, санхүүгийн байдал, хэрэглэгчдийн хэрэгцээг хангаж байгаа эсэх талаар хийсэн мониторингийн үйл ажиллагааны дүгнэлт, тайлан;

2.4.6. Тухайн жилийн үйл ажиллагааны тоон мэдээ, өмнөх жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, хувь нийлүүлэгчдэд зориулсан тайлан;

2.4.7. Аудитын зөвлөх үйлчилгээ, хуулийн үйлчилгээ худалдан авах томоохон гэрээний хуулбар;

2.4.8. Урд оны болон хянах хугацааны тоон мэдээлэлд орлого, зардал, усны алдагдал, одоогийн тарифаар тооцсон орлогын төсөөлөл, орлогын төлөвлөгөөний биелэлтийн мэдээ;

2.4.9. Дараа оны төсвийн төсөөлөлд зардлын зүйл бүрээр хийсэн тооцоо, олборлох эсвэл худалдан авах цэвэр ус, татан зайлуулах бохир усны хэмжээ, ариутгах татуургын үйлчилгээний зардлын таамаглал, үйлчилгээний биет хэмжээгээр илэрхийлсэн борлуулалтын орлого, алдагдал, эдийн засгийн байдал, борлуулалтын орлогын шаардагдах хэмжээний тооцоо, санал болгож буй тариф;

2.4.10. Эдийн засгийн нөхцөл, ханшийн зөрүү, эрх зүйн орчинд ирээдүйд гарч болзошгүй өөрчлөлт болон бусад макро өөрчлөлүүд тухайн компанийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлж болзошгүй байдлын талаарх мэдээлэл;

2.4.11. Зардлыг бууруулах, өсгөхгүй байх тал дээр удирдлагаас авч хэрэгжүүлсэн болон усны алдагдлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний талаарх эдээлэл, холбогдох ажлын тайлан, танилцуулга, баримт бичгүүд,

2.5. Холбоотой бүх мэдээллийг Монгол хэл дээр, мэдээллийн эх сурвалжийг заан, хавсаргаж ирүүлнэ. Мэдээллийг электрон файлаар болон хэвлэсэн материал ирүүлнэ.

Гурав. Тарифын саналыг хүлээн авах

3.1. Зөвлөлийн үнэ тарифын алба санал хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногт багтаан ирүүлсэн баримт материалын бүрдлийг хангаж байгаа эсэхийг шалгаж, дараах зүйлийг албан бичгээр тухайн ТЗЭ-д мэдэгдэнэ. Үүнд:

3.1.1. Ирүүлсэн баримт материал, бүрдэл нь зохих шаардлага хангаж байгаа учир үнэ тарифын саналыг албан ёсоор хүлээн авсан тухай;

3.1.2. Зарим тодорхой баримт бичиг нь зохих шаардлага хангахгүй байгаа учир үнэ тарифын саналыг хүлээн авах боломжгүй тул нэмэлт материал мэдээлэл ирүүлэх тухай;

3.1.3. Зөвлөлөөс тогтоосон /жил болон улирлаар тайлагнах/ зохицуулалтыг зөрчсөн ТЗЭ-ийн үнэ тарифын саналыг хүлээн авахаас татгалзаж болно. Эдгээр

тохиолдолд үнэ тарифын саналыг албан ёсоор хүлээн авсан гэж бүртгэхгүй бөгөөд энэ талаар хүсэлт гаргагч ТЗЭ-д албан ёсоор мэдэгдэнэ. Зөрчлийг арилгасны дараа санал, баримт материалыг тусгай зөвшөөрөл эзэмшигч дахин ирүүлж болно.

3.2. Зөвлөл ажлын 15 хоногийн дотор санал, баримт материалыг хүлээн авах боломжгүй талаар мэдэгдээгүй бол материалыг албан ёсоор хүлээн авсан гэж үзнэ. Энэ нь Зөвлөл болон бусад этгээдээс үнэ тарифын саналыг боловсруулахад шаардлагатай нэмэлт мэдээ, баримт шаардахгүй гэсэн үндэслэл болохгүй.

Дөрөв. Хэрэглэгчдэд мэдээлэх, хэрэглэгчдийг санал өгөх боломжоор хангах

4.1. ТЗЭ нь Зөвлөлд албан ёсоор саналаа хүргүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор /Ирүүлсэн санал, баримт бичиг нь шаардлага хангасан эсэхийг Зөвлөлөөс шийдвэрлэхээс ажлын 10 хоногийн өмнө/ өөрийн үйл ажиллагаа явуулж буй харъяалалын нутаг дэвсгэрийн хэрэглэгчдэд FM радио, телевиз, цахим хуудсаар үнэ тариф өөрчлүүлэх болсон шалтгаан, үнэ тарифын бүтцийн санал, шинэ үнэ тарифыг мөрдөхөөр төлөвлөж байгаа хугацаа зэргийг мэдээлж, холбогдох мэдээ материалтай танилцах боломжоор хангана.

4.2. Зөвлөл нь ТЗЭ-ээс үнэ тарифаа өөрчлүүлэх хүсэлт тавьж тооцоо, судалгааг ирүүлсэн, саналыг судалж байгаа талаараа олон нийтэд өдөр тутмын хэвлэлээр болон өөрийн веб хуудсаар зарлан мэдэгдэнэ.

4.3. Шаардлагатай гэж үзвэл тухайн компанийн үйлчилгээ явуулж байгаа нутаг дэвсгэрийн хот суурин газарт нэг эсвэл хэд хэдэн удаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж хэрэглэгчийн талаарх мэдээ, үйлчилгээний чанар, үйлчилгээний өргөжилт, санал болгож буй тарифын талаар олон нийтийн санал авна. Олон нийтийн хэлэлцүүлгийг Зөвлөлийн даргын баталсан журмын дагуу зохион байгуулна.

Тав. Нууц мэдээлэл

5.1. ТЗЭ байгууллагаас ирүүлсэн зарим мэдээлэл нь тухайн байгууллагын нууцтай холбоотой эсвэл уг мэдээллийг гаргаж өгөхөд өндөр зардал шаардагдахаар бол уг мэдээллийг ирүүлэхээс татгалзах хүсэлт, тодорхой үндэслэлээ Зөвлөлд гаргаж

болно. Хүсэлт нь үндэслэлтэй гэж үзвэл Зөвлөл уг мэдээллийг авахаас татгалзана. Зөвлөл нь дараах асуудалд шалгаж үзнэ. Үүнд:

5.1.1. ТЗЭ-ээс ирүүлсэн санал, баримт бичигтэй танилцаж, нууц мэдээлэл авалгүйгээр үнэ тарифын саналыг үр ашигтай хянах боломжтой эсэх;

5.1.2. Нууц гэж үзсэн, ирүүлэхээс татгалзсан мэдээлэлтэй хязгаарлагдмал хүрээнд танилцаж болох эсэх;

5.1.3. Нууцын мэдээлэл, баримт бичгийг хамгаалах талаар Зөвлөл арга хэмжээ авах бөгөөд мэдээллийг нийтэд задруулахаас хамгаална.

Зургаа. Хяналт, шалгалт, зөвшилцөл

6.1. ТЗЭ-ээс ирүүлсэн баримт бичиг болон тоон мэдээлэлд хариуцсан Үнэ тарифын албаны мэргэжилтэн судалгаа, шинжилгээ хийнэ. Тарифын саналтай танилцан, хянаж, эцсийн шийдвэр гаргах хугацаа нь тогтмол хугацааны /хуулиар зөвшөөрөгдсөн хугацаа/ үнэ тарифын саналд 90 хүртэл хоног, завсрын хугацааны /тарифт шууд нөлөөлдөг гаднын хүчин зүйлийн нөлөөлөл/ тарифын саналд 60 хүртэл хоног байна.

6.2. Зарим тодорхой нөхцөлд буюу нэмж ирүүлсэн мэдээллийг хянах шаардлагатай, эсвэл хөндлөнгийн экспертийн дүгнэлт хэрэгтэй, эсвэл шинэ мэдээ, баримт шалгах, баталгаа гаргах зэрэг үед Зөвлөлөөс хугацааг 30 хоногоор сунгаж болно.

6.3. Хянан шалгасан мэргэжилтэн шаардлагатай гэж үзвэл тухайн байгууллагын санхүүгийн холбогдолтой нэмэлт мэдээлэл бусад тайлан, гэрээ хэлцэл, хурлын тэмдэглэлийг хувиан ирүүлэхийг хүсэлт гаргагч ТЗЭ-ээс шаардаж болно. Талууд өөр хугацаа тогтоогүй бол шаардсан мэдээг ажлын 5 хоногийн дотор гаргаж ирүүлнэ.

6.4. Баримт бичиг боловсруулахтай холбоотой маргааныг Зөвлөлийн дарга шийдвэрлэнэ.

6.5. Шаардсан мэдээг гаргаж өгч чадахгүй бол нөхцөл байдлыг бодитойгоор үнэлсний дараа Зөвлөл дарга үнэ тарифын саналыг үргэлжлүүлэн хянахыг түдгэлзүүлж болно.

6.6. ТЗЭ нь үнээ өөрчлүүлснээс хойш 6 сарын дотор дахин Зөвлөлд саналаа ирүүлэхгүй.

6.7. Хяналтын явцад хүсэлт гаргагч ТЗЭ-ээс Зөвлөлийн мэргэжилтэнтэй байгууллагын бичилт, орлого, зардал, хөрөнгө оруулалт, санхүүгийн тоо баримт, ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зардал, алдагдал гэх мэт асуудлаар уулзан ярилцаж, тайлбарлаж болно.

6.8. Хяналтын явцад аль нэг тал нь Зөвлөлийн зохицуулагчтай бүх талууд оролцоогүй үед хянагдаж буй асуудлаар уулзаж, ярилцахыг хориглоно. Зөвлөлтэй харилцах асуудал нь Үнэ тарифын албаны ажилтнуудтай харилцахаар хязгаарлагдана.

6.9. Тухайн орон нутгийн хэрэглэгчийн төлөөлөгч хяналтын явцад хүсэлт гаргагч ТЗЭ-ээс гаргасан санал, баримт материалтай танилцах хүсвэл нууцад хамаарахаас бусад материалыг хэрэглэгчдийн төлөөлөгчид үнэгүй гаргаж өгнө.

6.10. Хяналтын үндсэн зорилго нь ирүүлсэн баримт мэдээллийн үндэслэл, үнэн зөв эсэх, Зөвлөлд санал болгосон үнэ тарифын тооцоо алдаагүй эсэхийг шалгахад оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд Зөвлөл нь ашиг сонирхол нь хөндөгдөж буй ТЗЭ-ийг хамтран ажиллах, мэдээлэл солилцох, маргаанаа харилцан тохиролцож шийдвэрлэхийг дэмжинэ.

6.11. Асуудлын зохистой шийдлийг олох, тарифын саналын талаар зөвлөмж өгөхийн тул Зөвлөлийн тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн Зөвлөлийн байранд хүсэлт гаргасан ТЗЭ, Зөвлөлийн мэргэжилтэн, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөлөл, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон мэргэжлийн байгууллагын төлөөлөл түүнчлэн ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүдийг оролцуулан хуралдаан зохион байгуулна.

6.12. Хуралдаан, хэлэлцээрийн дүнд бүх асуудлууд дээр нэгдсэн ойлголтонд хүрвэл бүх оролцогчдын санал, дүгнэлтийг нэгтгэн гарын үсэг зуруулан баталгаажуулж авна.

Долоо. Шийдвэр гаргах

7.1. Үнэ тарифын алба тухайн саналын хураангуй, хэлэлцсэн гол асуудлууд, үнэ тарифын саналын талаарх зөвлөмж зэрэг шаардлагатай бүх мэдээллийг Зөвлөлд бүрдүүлж өгнө.

7.2. Үнэ тарифын хяналт, шалгалт, хэлэлцүүлэг, ирүүлсэн санал, зөвлөмжийг үндэслэн Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай үнийн саналыг зөвшилцөн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

7.3. Эцсийн шийдвэрийг ТЗЭ-д хүргүүлснээс хойш ажлын хоёр долоо хоногийн дотор хүсэлт гаргагч зөвлөлийг тооцоонд алдаа гаргасан, үнэ тарифын аргачлалыг зөрчсөн, хууль, зохицуулалттай зөрчилдсөн гэж үзвэл Зөвлөлд хүсэлт гарган, гаргасан шийдвэрээ дахин хянан үзэхийг хүсч болно. Зөвлөл нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын хоёр долоо хоногийн дотор шийдвэр гаргаж, хүсэлт гаргагч ТЗЭ-д албан ёсоор бичгээр мэдэгдэнэ.

7.4. Үнэ тарифын санал, хяналтын явцад бүрдүүлсэн холбогдох бүх материалуудыг, эцсийн шийдвэрийн бүртгэл, хяналтын картын дугаарын дагуу архивлан хадгалж, холбогдох этгээдүүд үзэж танилцах боломжоор хангана.

--- о О о ---